



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 14/16

Номгон


Хүүхдийн төлөө зөвлөлийн тайланг
хэлэлцэж, чиглэл өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2, 38.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг 98,0 хувь буюу "Үр дүнтэй" гэж дүгнэсүгэй.

2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн эрхийг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлахад шаардлагатай хөрөнгийг 2027 оны төсөвт тусгах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн (Э.Энхбат)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Энхжаргал), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хяналт шинжилгээний хороо (Д.Ууганцэцэг)-д даалгасугай.

ДАРГА  Б.БАТСУУРЬ

642601052